

Бид экстеиншийн чиглэлийн вйл ажиллагаа явуулдаг бусад байгууллагуудтай хамтран малчдад мэдлэг тггээх, боломжит технологи дамжуулах, нэвтрүүлэх ажлыг хвчээ нэгтгэн, хамтран хэрэгжүүлж, экстеиншийн вйл ажиллагааг орон нутагт бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулахаар ажиллаж байна.

Манай байгууллага нь Ховд, Баян-Олгий, Увс, Завхан, Баян-Хонгор, Говь-Алтай, Архангай, Тов, Дундговь гэсэн 9 аймгийн 66 суманд тогтвортой амьжиргааны үндсийг бүрдүүлэх зорилгоор бэлчээрийн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, хамгаалах малчдын хамтын нийгэмлэгийг бэхжүүлэх зорилгоор 23000 орчим малчин орхийг хамарсан 433 бэлчээр ашиглалтын хэсгийг (БАХ), 66 суманд БАХ-ын холбоо, 14 аймагт аймгийн холбоог байгууллаа.

Малчдад хэрэгцээт технологийн зовломжийг судалгааныхаа багаар, тэргүүн туршлага, шинэ санаачлагыг хамтын нийгэмлэг хогжлийн албаараа дамжуулан нэгтгэж, зовлохийн багаар хянуулан мэдээлэлийн санд нэгтгэдэг (1-р бүдvvвч). Сургалтыг мэргэжилтнүүдийнхээ чадавхид тулгуурлан, зоволгоог зовлохийн багаар дамжуулан зарим нарийн мэргэжлийн сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран хийдэг. Улирал тутамд “Бэлчээр ногоон алт” сонин гаргаж малчдад мэдээлэлийг тггээдэг.

Зовлох вйл ажиллагааг явуулахдаа дараах зарчмыг баримталдаг. **Үүнд:**

- Үйлчилгээ аль болох бодитой, малчдын мэдлэг чадварын түвшинд тохирсон, орон нутгийн хвчин чадалд нийцсэн байх,
- Орон нутгийн онцлог, чиглэсэн вйл ажиллагаанд тохирсон байх,
- Экстэншийн ажилтанг малчдын хэсэг дотроос сонгох,
- Экстэншийн ажилтан нь зовлож буй технологийн талаар мэдлэгтэй, сургалтанд хамрагдсан байх,
- Судалгааны ажил нь экстеншийн вйл ажиллагаатай уялдаж байх,
- Харилцагчдад тулгарч буй бэрхшээлийн мөн чанар, уялдааг бодитоор таниулж, ингэснээр бэрхшээлийг шийдэх хувилбаруудыг олж илрүүлэх чадвар эзэмшүүлэх,

Энэ жилээс малчдад хэрэгцээт технологи, зовломж, тэргүүн туршлагыг нэвтрүүлэх, дамжуулах вйлчилгээ, мэдлэг дээшлүүлэх чиглэлийн сургалтуудыг “Малчнаас – Малчинд” хвргэнэ гэсэн зарчмын дагуу БАХ дотроосоо 3 чиглэлээр (бэлчээр хамгаалах, малын чанар сайжруулах, малчдын орлого нэмэгдүүлэх маркетинг) нутгийн туршлагатай малчдыг сонгон экстеншийн вйл ажиллагааг явуулахаар бүтцийн зохион байгуулалтанд ороод байна.



МБМХ звгээс дараахь чиглэлээр хамтран ажиллахыг санал болгож байна. **Үвнд:**

- Дээрхи байгууллагуудтай манай тосол хэрэгжvвлж буй сумдад хийх вйл ажиллагааны толовлогоотэй танилцаж вйл ажиллагаагаа уялдуулах,
- Дээрхи байгууллагаас зохион байгуулж буй сургалтанд тосол хэрэгжиж буй сумдын малчдыг хамруулах боломжийг судлаж хамтран ажиллах,
- Дээрхи байгууллагаас малчдад зориулан гаргасан зовломж, технологиудийг тослийн сумдад хэрэгжvвлэх боломжийг судлаж хамтран ажиллах.